

Монголын эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбоо

ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛ БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. ТАНД БОЛОН ТАНАЙ БАЙГУУЛЛАГА ХАМТ ОЛОНД ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛ БАЙГУУЛАХ ХҮСЭЛ СОНИРХОЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА БАЙНА УУ?

Цайны газар, ажлын байр ер нь хаана ч ажилчид энэ талаар ярилцаж байна уу үгүй юу, ҮЭ байгуулах талаар яригдаж байгаа ч яаж байгуулахаа мэдэхгүй байна уу гэдгийг мэдэж авах хэрэгтэй. Эсвэл энэ талаар огт яригдахгүй ч байж болох юм, тэгвэл та энэ талаар яриа эхлүүлэх хэрэгтэй. Заавал аливаа нэг дарамт шахалт, доромжлол мөлжлөгийг амсаж байж ҮЭ байгуулах ёстой юу гэвэл үгүй. Байгаа нөхцөл байдлаа ирээдүйд улам сайжруулах, сайн сайхан ирээдүй бүтээхийн төлөө, таны ажлын байрыг хамгаалах, нийгмийн асуудлуудыг чинь тодорхой хэмжээнд шийдвэрлэхийн төлөө ажиллах ҮЭ хэрэгтэй л байгаа шүү дээ. ҮЭ байгуулах талаар таны саналыг хамт олон тан дэмжиж байвал ҮЭ байгуулах эхний шат тавигджээ гэсэн үг.

2. Үйлдвэрчний эвлэлийг хэрхэн байгуулах вэ?

Монгол улсад ҮЭ-ийн үйл ажиллагааг зохицуулсан “ҮЭ-үүдийн эрхийн тухай хууль” 1991 онд батлагдсан бөгөөд ҮЭ-ийн байгууллагууд нь мэргэжил-үйлдвэрийнхээ шинжээр эвлэлдэн нэгдэж, нутаг дэвсгэрийнхээ ҮЭ-д харъяалалтай байхаар зохицуулсан байдаг. Монгол улсын хэмжээнд үндэсний нэг ҮЭ-ийн байгууллага байдаг бөгөөд Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо юм. Энэ холбоо нь дэргэдээ мэргэжил-үйлдвэрлэлийн шинжээр нэгдсэн 14 холбоотой.

Танай байгууллага үйл ажиллагааны онцлог, мэргэжлийн шинжээрээ эдгээрийн холбоодын аль нэгэнд эвлэлдэн нэгдэж гишүүнчлэгдэнэ гэсэн үг. Хамт олны хурлаа зохион байгуулахаас өмнө холбогдох салбарын ҮЭ-ийн байгууллагад хандан зөвлөгөө авахад гэмгүй бөгөөд ҮЭ байгуулахад бүрдүүлэх шаардлагатай баримт бичгүүдийг судлаж түүний дагуу бүрдүүлэх хэрэгтэй.

ҮЭ байгуулахад шаардлагатай баримт бичгүүдийг бүрдүүлэн Улсын бүртгэлийн тухай хуулийн дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлж гэрчилгээ авснаар танай ҮЭ-ийн байгууллага үйл ажиллагаа явуулах хууль эрх зүйн үндэс бүрдэж байгаа юм.

Та эрчим хүч, геологи, уул уурхайн салбарын компани, хуулийн этгээдэд ажилладаг бол дараах загварын дагуу ҮЭ-ийн хороогоо байгуулаарай.

Үйлдвэрчний эвлэлийг Хуулийн этгээдээр бүртгүүлэхэд дараах баримт бичиг шаардлагатай болно.

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын <https://burtgel.gov.mn/> хаягаар орж бүртгэлийн маягтуудыг татаж аваарай.

ҮЭ-ийн хороо байгуулах, тэргүүлэгчид сонгох, ... тогтоолуудыг А4 хэмжээгээр гаргаж, байгууллагын нэр, тогтоол дээрх хүмүүсийн овог нэрийг бүтэн бичихийг анхаарна уу.

Загвар 1 -3 хувь үйлдэх

.....-ИЙН АЖИЛЧДЫН ХУРЛЫН ТОГТООЛ

20... оны сарын өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

ҮЭ-ийн хороо байгуулах тухай
.....-н ажилчдын хурлаас ТОГТООХ НЬ :

1.компанийн ажилтнуудын **хөдөлмөрлөх эрх, нийгмийн хамгааллын баталгааг хуулийн хүрээнд хангах зорилгоор** /шүүлгэсэн нэр/-ийн ҮЭ-ийн
2. хороог ҮЭ-үүдийн эрхийн тухай хуулинд заасны дагуу хуралд оролцсон ажилчдын дийлэнх олонхийн саналыг үндэслэн байгуулсугай.

Хурлын тэргүүлэгчид:

..... /P.PPPPPPP/

..... /P.PPPPPPP/

..... /P.PPPPPPP/

Загвар 2 Хурлын тэмдэглэл 3 хувь үйлдэх

.....ажилчдын хурлын тэмдэглэл

..... компанийн ажилчдын хурлыг **20... оны ... сарын ... өдөр ... цагт хаана зарлаж** хуралдуулсан. Компанийн хэмжээнд хичнээн ажилчидтай одоогийн хуралд хичнээн хүн оролцсон. Хуралд хичнээн ажилчид оролцсон. Хурлыг хэн хэн даргалсан /3 хүн хангалттай/.

- Яагаад ҮЭ-ийн хороо байгуулах шаардлагатай гэж үзсэн, ямар эрх зүйн зохицуулалттай байгууллага болох, ямар зорилгоор ҮЭ байгуулахтай холбоотой юу юу яригдсан.
- Хуралд оролцсон хүмүүсийн хэдэн хувь нь дэмжсэн.
- Хуралд оролцсон хүмүүсийн хэлсэн үг, санал, шүүмжлэл байгаа бол бичих.
- Цаашид ҮЭ-ийн хорооны дотоод асуудалтай холбоотой хурал үргэлжлэх тул дэмжээгүй хүмүүсийг гаргах – **шаардлагатай бол бичих**
- Хуралд оролцсон хүмүүсийн бүртгэл гарын үсэгтэй хуудсыг тэмдэглэлд хавсаргана.

Тэмдэглэсэн хөтөлсөн: 3.33333333

Танилцсан: Хурлын тэргүүлэгчид 3.33333

3.33333

3.33333

/шүүлгэсэн нэр/-ИЙН БҮХ
ГИШҮҮДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

20.... оны сарын өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

ҮЭ-ийн хорооны дотоод асуудал хэлэлцэх тухай

/шүүлгэсэн нэр/- ҮЭ-ийн хорооны бүх гишүүдийн хурлаас ТОГТООХ НЬ:

1.-ийн ҮЭ-ийн хорооны гишүүний татварыг хуульд заасны дагуу цалингийн 1 хувь эсвэл хэд байхаар тогтсон/-р сар бүр ҮЭ-ийн гишүүнээс бэлэн бусаар хурааж байхаар тогтсугай.
2. ҮЭ-ийн хорооны даргаар Хэний хэн, тэргүүлэгчдээр Хэний хэн, Хэний хэн нарыг сонгож баталсугай.
3. ҮЭ-үүдийн эрхийн тухай хуулийн дагуу мэргэжил үйлдвэрлэлийн салбарын ҮЭ-ийн холбоо болох МЭХГУУ-н ҮЭ-ийн холбоонд элсэж тус холбооны дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулсугай.
4.-ийн ҮЭ-ийн хороог Хуулийн этгээдийн бүртгэлд бүртгүүлж цаашид холбогдох дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулахыг ҮЭ-ийн хорооны дарга, тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.
5. Хуулийн этгээдийн эрх үүсэж, ҮЭ-ийн гишүүний татвар хураагдахаар ҮЭ-ийн хорооны нягтлан бодогч, Хяналтын хорооны гишүүдийг сонгох хурал зохион байгуулахыг ҮЭ-ийн хорооны дарга, тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

Хурлын тэргүүлэгчид: /P.PPPPPPP/
 /P.PPPPPPP/
 /P.PPPPPPP/

Загвар 4 Хурлын тэмдэглэл -3 хувь үйлдэх

.....ҮЭ-ийн хорооны бүх гишүүдийн хурлын тэмдэглэл

- Хурал хэзээ хэдэн цаг хаана болсон
- Хуралд ҮЭ-ийн хэдэн гишүүнээс хэд оролцсон /ирц хувь
- Хурлыг хэн хэн удирдсан
- Хурлаар юу юу хэлэлцсэн /татварын хувь, ҮЭ-ийн даргаар хэн ямар албан тушаалтай хүн сонгогдсон, ҮЭ-ийн тэргүүлэгч гишүүдийн тоог хэд байхаар тогтож хэн хэн сонгогдсон
- Ямар дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулах, аль салбарт элсэх /МЭХГУУ-н ҮЭ-ийн дүрэм, хамтын хэлэлцээрийн давуу тал/
- Тус ҮЭ-ийн хороог ямар эрх зүйн үндэслэлээр яаж ажиллахыг тогтох, хэнд ямар үүрэг хүлээлгэх
- Хэн ямар санал гаргасан талаар бичнэ
- Цаашид ҮЭ-ийн нягтлан бодогч, дотоод хяналтыг хэрэгжүүлэх Хяналтын хорооны гишүүдийг хэзээ хэрхэн сонгохоор тохирсон
- Хуралд оролцсон бүх гишүүдийн бүртгэлийн хуудас /толгойг нь анхаарна уу, ямар ч толгойгүй хуудас дээр гарын үсэг зуруулж БОЛОХГҮЙ/

Тэмдэглэсэн хөтөлсөн: 3.33333333

Танилцсан: Хурлын тэргүүлэгчид 3.33333

3.33333

3.33333

.....-ИЙН ҮЭ-ИЙН ХОРООНЫ ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

20.... оны сарын өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

ҮЭ-ийн үйл ажиллагаа явуулах талаар

..... ҮЭ-ийн хорооны тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

1. МЭХГУУ-н ҮЭ-ийн хорооны дүрмийг цаашид мөрдөж ажиллах тул салбарын ҮЭ-ийн холбооны гишүүн байгууллагаар бүртгүүлж, мэргэжил арга зүйн туслалцаа авч ажиллах нь зүйтэй гэж үзсүгэй.
2. Тус ҮЭ-ийг сарын ... тэдний дотор холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэхийг ҮЭ-ийн хорооны дарга-д үүрэг болгосугай.
3. Улсын тэмдэгтийн хураамж /Төрийн бус байгууллага бүртгүүлсэн хураамж/ төгрөгийг Голомт-4 банкны 1401002649 тоот дансанд тушаахыг /н./-д зөвшөөрсүгэй.

ТЭРГҮҮЛЭГЧИД

даргын нэр.....
тэргүүлэгчийн нэр.....
тэргүүлэгчийн нэр.....

Загвар 6 Хурлын тэмдэглэл – 3 хувь үйлдэх

.....ҮЭ-ийн хорооны тэргүүлэгчдийн хурлын тэмдэглэл

- Хэдэн сарын хэдний өдөр хуралдсан
- Ямар асуудал хэлэлцсэн
- Хэн хэн ямар санал гаргасан /үг хэлсэн/
- МЭХГУУ-н ҮЭХ-нд элсэх тухай
- **Тэргүүлэгчдийн нэг нь гарын үсэг зурж, ҮЭХ-ны дарга танилцаж гарын үсэг зурна. /Цаашид ҮЭ-ийн үйл ажиллагаатай холбоотой бүх шийдвэр тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэгдэх тул 01 дугаараас үргэлжлүүлэн тогтоолуудаа дугаарлаж явна. Тогтоол дээр дарга тэргүүлэгчид бүгд гарын үсэг зурж байна. 2 хувь гаргаж байна. Санхүүдээ 1 хувийг нь хадгална/**
- Улсын бүртгэлд бүртгүүлэх зардал гэрчилгээ, тамга, данс нээлгэхтэй холбоотой хэдэн төгрөгний зардал гарах, хэн урьдчилж гаргахтай холбоотой асуудал хэлэлцэх

Тэмдэглэл хөтөлсөн: Тэргүүлэгч

Хянасан дарга:

.....-ийн ҮЭ-ийн хороо

20... оны ... сарын ... өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Монголын Эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбоонд

Гишүүн байгууллагаар элсэх тухай

.....-ийн ҮЭ-ийн хороо нь оны.... сарын-ны өдөр эвлэлдэн нэгдэж эрх ашгаа хамтран хамгаалахаар байгуулагдсан ба одоогийн байдлааргишүүнтэй, тэргүүлэгчтэй үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна.

.....ҮЭ-ийн хорооны бүх гишүүдийн хурлаар танай дүрмийг мөрдөж ажиллахаар болсон тул гишүүн байгууллагаар бүртгэж авч хуулийн этгээдийн эрх эдлэн, үүрэг хүлээж ажиллахад мэргэжил арга зүйн талаар туслалцаа үзүүлэн хамтран ажиллана уу.

Манай ҮЭ-ийн хороог улсын бүртгэлд бүртгүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлнэ үү.

Жич: ҮЭ-ийн хороог үүсгэн байгуулахтай холбоотой тогтоол, хурлын тэмдэглэл, албан хүсэлтийг хавсаргав.

Дарга Р.PPPPPPPP

.....-ийн ҮЭ-ийн хороо

20... оны ... сарын ... өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Оюуны өмч улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт

Хуулийн этгээдээр бүртгүүлэх тухай

Монгол Улсын хуулийн хүрээнд хөдөлмөрлөх эрхээ хэрэгжүүлэх, түүнтэй холбогдсон хууль ёсны эрх ашгаа хамтран хамгаалах зорилгоор өөрсдийн сайн дурын үндсэн дээр 20... оны ... сард гишүүнтэйгээр байгуулагдаж Монголын Эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбооны дүрмийг хүлээн зөвшөөрч гишүүн байгууллагаар элсэж үйл ажиллагаа явуулах болно. Одоо тус ҮЭ-ийн хороо нь тэргүүлэгчтэй, гишүүнтэй. “ҮЭ-үүдийн эрхийн тухай хууль”,

“Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэхээр энэхүү өргөдлийг өргөн барьж байна.

Жич: ҮЭ-ийн хороог үүсгэн байгуулахтай холбоотой баримт бичгүүдийг хавсаргав.

Дарга Р.PPPPPPPP

Танай ҮЭ-ийн хороонд байх шаардлагатай бүртгэл

.....-ИЙН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН
ХОРООНЫ ГИШҮҮДИЙН БҮРТГЭЛ /**өөрийн байгууллагын онцлогт тохируулсан бүртгэлийн sheet үүсгэж болно/**

ҮЭ-ийн хорооны гишүүн бүр дараах маягтыг бөглөх шаардлагатай.

- Ажилтан бүр 2 хувь бөглөж ҮЭ-ийн хороондоо өгнө.
- Өөрийн байгууллагын онцлогод тохируулан засаж болно.

..... ХХК-ИЙН ҮЭ-ИЙН ХОРООНД

.....ХХК-ийн ҮЭ-ийн хорооны гишүүнээр элсэж, гишүүний татварыг **цалин орлогын 1 хувиар /хурлаар хэрхэн тогтоосон тооцон/** сар бүр цалингаасаа бэлэн бусаар хураалгахыг зөвшөөрч байна.

Гишүүний татварыг цаашид сар бүр-р **хувиар** тооцон цалингаас бэлэн бусаар хурааж байхыг үүгээр зөвшөөрч байгаа бөгөөд энэхүү суутгалыг зогсоох тухайгаа жич мэдэгдэх болно.

Мөн энэхүү бичгэн зөвшөөрлийг ХХК-ийн санхүүд танилцуулж ҮЭ-ийн гишүүний татварыг хураалгахыг ҮЭ-ийн хорооны дарга, тэргүүлэгчдэд зөвшөөрч байна.

Овог нэр:

Регистрийн дугаар

Албан тушаал буюу ажлын байрны нэр

Харъяалагдах газар, хэлтэс :

202..... оны сарын

Гарын үсэг

3. Үйлдвэрчний эвлэлээ байгуулахдаа дараах зүйлсийг анхаараарай!!!

- Хамт олны санаа нэгдсэн дээрээс нь хурлаас гарах тогтоол, бичиг баримтуудыг судлаж холбогдох мэргэжлийн хүмүүстэй уулзан зөвлөгөө авсан болохоор хурлаа зохион байгуулах нь үлдлээ.
- Хурлаа амжилттай зохион байгуулахын тулд байгууллагынхаа хөдөлмөрийн дотоод журмыг сайтар судлах ёстой.
- Та бүхний зарласан хурал хүмүүст аль болох тохиромжтой, нийт ажилтнуудын олонхи нь оролцох боломжтой цагийг сонгох бөгөөд хурлын заал танхимаа ч хүртээмжтэй байдлаар сонгох хэрэгтэй.
- Бүх ажилтнуудад хамаатай асуудал болохоор хурлын ирц чухал учир хурал болохоос хэд хоногийн өмнө зарлаж, ажилтнуудад аль болох олон хэлбэрээр мэдээлэлээ хүргэх нь зүйтэй.
- Мэдээлэлийн самбар, мэйл хаягаар зарлах, сонсгол хурал дээр мэдээллэх гэх мэт.
- Хамт олны хурлаар ҮЭ байгуулах асуудал дэмжлэг авбал хурлын тогтоол үйлдэж баталгаажуулах бөгөөд ҮЭ-ийг удирдаж ажиллах ҮЭ-ийн хорооны тэргүүлэгч гишүүд, даргыг хамт олноос санал авч сонгож мөн тогтоол гаргаж баталгаажуулна.

.....-ИЙН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН
ХОРООНЫ ТЭРГҮҮЛЭГЧ ГИШҮҮДИЙН БҮРТГЭЛ

1	Овог нэр	Хүйс	Албан тушаал	Регистрийн дугаар	Гарын үсэг	Батлахны дугаар

ҮЭ-ийн хорооны дарга / /

Ажилтан бүр 2 хувь бөглөж ҮЭ-ийн хороондоо өгнө.

..... **ХХК-ИЙН ҮЭ-ИЙН ХОРООНД**

.....ХХК-ийн ҮЭ-ийн хорооны гишүүнээр элсэж, гишүүний татварыг **цалин орлогын 1 хувиар /хурлаар хэрхэн тогтоосон тооцон/** сар бүр цалингаасаа бэлэн бусаар хураалгахыг зөвшөөрч байна.

Гишүүний татварыг цаашид сар бүр-р **хувиар** тооцон цалингаас бэлэн бусаар хурааж байхыг үүгээр зөвшөөрч байгаа бөгөөд энэхүү суутгалыг зогсоох тухайгаа жич мэдэгдэх болно.

Мөн энэхүү бичгэн зөвшөөрлийг ХХК-ийн санхүүд танилцуулж ҮЭ-ийн гишүүний татварыг хураалгахыг ҮЭ-ийн хорооны дарга, тэргүүлэгчдэд зөвшөөрч байна.

Овог нэр:

Регистрийн дугаар

Албан тушаал буюу ажлын байрны нэр

Харъяалагдах газар, хэлтэс :

201.... оны ... сарын

Гарын үсэг

- **Өөрийн байгууллагын онцлогод тохируулан засаж болно.**